

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Барилга, хот байгуулалтын яам

Санхүү, хөрөнгө оруулалтын газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын  
дарга

Эрхэлсэн түшмэл, ТЗ-13

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

15170, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII  
байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудыг хэрэгжүүлж, салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлтөд санхүү, төсвийн асуудлаар дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж болон урсгал зардлыг төлөвлөх, батлуулах, хуваарилах, санхүүжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах, худалдан авалт, гэрээний хэрэгжилтийг хангуулахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд нэгжийг удирдан гүйцэтгэлийн үр дүнг Төрийн нарийн бичгийн даргын өмнө хүлээнэ.

Албан тушаалын зорилт:

- 1.Салбарын төсвийн нэгдсэн бодлого, төлөвлөлтөд санхүү, төсвийн асуудлаар санал, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- 2.Урсгал зардал болон улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжаар хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлуулах, хуваарилах, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- 3.Салбарын хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн үр өгөөжийг сайжруулах, төрийн өмчийн бүртгэл, ашиглалтыг санхүүгийн нэгдсэн бодлогоор зохицуулж, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- 4.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 5.Удирдлагаас хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт                    | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг                                                                                                                                                                   | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт                             | Хариуцлага, оролцооны хэлбэр<br>Туслах - Т,<br>Хариуцан гүйцэтгэх - Г<br>Хянах – Х<br>Шийдвэрлэх – Ш |
|---------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Барилга, хот байгуулалтын яам болон харьяа байгууллагуудын урсгал төсвийн нэгтгэл хийж, сайдын багцын урсгал төсвийг төлөвлөх;                                                                     | Салбарын хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан байна.       | Х, Г                                                                                                 |
|                           | 2.Урсгал төсвийн төслийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, түүнийг УИХ-аар батлуулахад дэмжлэг үзүүлэх;                                                                                            | Салбарын хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан байна.       | Х, Г                                                                                                 |
|                           | 3.Салбарын хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг хийж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, батлуулахад дэмжлэг үзүүлэх;                                                                            | Салбарын хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан байна.       | Х, Г                                                                                                 |
|                           | 4.Салбарын хэмжээнд батлагдсан хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж болон урсгал зардлыг хуваарилах, санхүүжилтэд хяналт тавих;                                                                  | Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.         | Х, Г                                                                                                 |
|                           | 5.Салбарын хэмжээнд нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн хөтлөх, Сайдын багцын санхүүгийн тайлангийн нэгтгэлд мэргэжлийн удирдлагаар чиглүүлэх.                                  | Хууль эрхийн хүрээнд нийцсэн, хэрэгжилт хангагдсан байна. | Х, Г                                                                                                 |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалт болон урсгал төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, удирдлага зохицуулалтаар дэмжлэг үзүүлэх; | Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.         | Х, Г                                                                                                 |



|                           |                                                                                                                                                                                                                                                                    |                                                                            |      |
|---------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------|------|
|                           | 2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, үр ашгийг дээшлүүлэх, салбар хоорондын болон нутгийн захиргааны холбогдох байгууллагуудын уялдааг сайжруулах чиглэлээр санал боловсруулах, шаардлагатай зохицуулалтыг хийж, шийдвэрлүүлэх; | Хууль эрхийн хүрээнд нийцсэн байна.                                        | Х, Г |
|                           | 3.Худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж, дэмжлэг үзүүлэх;                                                                                                                                                                | Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.                          | Х, Г |
|                           | 4.Салбарын хөрөнгө оруулалтын судалгаа, мэдээллийг бүрдүүлж, түүнийг шинэчлэх, баяжуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, яамны удирдлага, нэгж, холбогдох байгууллагыг мэдээ, мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх.                                                       | Санхүү, хөрөнгө оруулалтын үнэн зөв, мэдээллээр хангагдсан байна.          | Х, Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Салбарын хэмжээнд гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжүүлэгч байгууллагатай гэрээ хэлэлцээр байгуулах шатны санхүүгийн тооцоог хийхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;                                                           | Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ болон түүний өгөөжийг дээшлүүлсэн байна. | Х, Г |
|                           | 2.Салбарын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт, хэрэгжилтэд хяналт тавих;                                                                                                                                            | Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.                          | Х, Г |
|                           | 3.Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулах, тэдгээрийн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;                                                                                                                                       | Хууль эрхийн хүрээнд нийцсэн, хэрэгжилтийг сайжруулсан байна.              | Х, Г |
|                           | 4.Төслийн нэгжүүдийн жил, улирлын санхүүгийн төлөвлөгөөг хянах, хэрэгжилтэд хяналт тавих;                                                                                                                                                                          | Хууль эрхийн хүрээнд нийцсэн байна.                                        | Х, Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Газрын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, нэгжээс төсвийн шууд захирагчтай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангуулах;                                                                                                          | Хэрэгжилтийг хангуулан ажилласан байх;                                     | Г, Х |
|                           | 2.Газрын ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих, ажлын үр дүнг үнэлж дүгнэн тайлагнах;                                                                                                                                              | Хэрэгжилтийг хангуулан ажилласан байх;                                     | Г,Х  |
|                           | 3.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үр дүнг тайлагнах;                                                                                                                                                                                   | Хэрэгжилтийг хангуулан ажилласан байх;                                     | Г    |
|                           | 4.Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргыг мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх;                                                                                                                                                           | Хэрэгжилтийг хангуулан ажилласан байх;                                     | Г    |



|                           |                                                                                                                                                                   |                                                                         |      |
|---------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------|------|
|                           | 5.Дотоод дүрэм, журмыг нэгжийнхээ хэмжээнд мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;                                                                 | Хэрэгжилтийг хангуулан ажилласан байх;                                  | Г,Х  |
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;                                                                             | Ёс зүйн болон бусад төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлсэн байна. | Х, Г |
|                           | 2.Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх;                    | Цаг хугацаандаа, шударгаар биелүүлж, гүйцэтгэсэн байна.                 | Х, Г |
|                           | 3.Удирдлагыг өөрийн эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил, арга зүй, удирдлага зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх. | Мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдал бүрэн хангагдсан байна.      | Х, Г |

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

|           |                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
|-----------|--------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Боловсрол |                          | - Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
| Мэргэжил  |                          | - Санхүү, банк, даатгал /0412/;<br>- нягтлан бодох бүртгэл, татвар /0411/;<br>- төрийн удирдлага /041303/.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| Мэргэшил  |                          | - Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;<br>- эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн байх;                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| Туршлага  |                          | - Төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах | - Нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх;<br>- гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, зөрүүг арилгах чиглэлээр зөвлөгөө, чиглэл өгөх чадвартай байх;<br>- байгууллагын эрсдэлийн удирдлага, эрхэмлэх зүйлсийг хэрэгжүүлэх;<br>- албан хаагчдад ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах;<br>- албан хаагчдын санал, бодлыг нь сонсох, ажлын үр дүнг нь зөв үнэлэх, урам өгөх, эргэх холбоотой ажиллах, тэднийг мэдээллээр хангах;<br>- албан хаагчдын хувийн зан төлөв зэрэг хувь хүнтэй холбоотой асуудлыг мэдэрч, удирдах;<br>- сөргөлдөөнийг эв зүйгээр зохицуулах;<br>- бусад. |
|           | Дүн шинжилгээ хийх       | - судалгааны арга зүй эзэмшсэн байх;<br>- мэдээлэлд тулгуурлан системийн шинжилгээ хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;<br>- судалгааны үр дүнг харьцуулан үнэлэх, тайлбарлах;<br>- бодлогын санал, зөвлөмж, дүгнэлтийн төсөл боловсруулах;<br>- бусад.                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|           | Асуудал шийдвэрлэх       | - хуульд нийцсэн шийдвэр гаргах;<br>- тэгш, шударга, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |





|  |           |                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|--|-----------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|  |           | гаргах;<br>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээг баримталж шийдвэр гаргах;<br>- гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээх;<br>бусад.                                                                                                                                                                                      |
|  | Манлайлах | - ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх;<br>- ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах;<br>- байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх;<br>- тууштай, зарчимч, ажил хэрэгч, халамжлах зэргээр үлгэрлэх;<br>- цагийн менежмент сайтай байх;<br>- бусад. |
|  | Бусад     | - шаардлагатай хэрэглээний программ хангамжийг үйл ажиллагаандаа ашиглах чадвартай байх;<br>- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;<br>- англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;<br>- багаар ажиллах чадвартай байх.                                |

#### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах

албан тушаалын нэр, тоо:

- Хэлтсийн дарга
- тасгийн дарга
- ахлах шинжээч
- шинжээч
- ахлах мэргэжилтэн
- мэргэжилтэн
- ахлах зохион байгуулагч

Нийт: 9

Бусад харилцах субъект:

- УИХ, ЗГХЭГ, ЕТГ болон УИХ, ЗГ-ын харьяа төрийн захиргааны байгууллагууд;
- Яам, агентлаг, нутгийн захиргааны болон бусад төрийн байгууллагууд;
- Төрийн бус байгууллагууд;
- Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд;
- Иргэн, хуулийн этгээд.

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА

 Д. БАЯРСАЙХАН  
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2020 оны 10 дугаар сарын 14 -ны өдөр

Байгууллагын нэр:  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 20 10 14

Дугаар: 340



Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....  
(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА .....

СМ  
(Гарын үсэг)

С.МАГНАЙСҮРЭН  
(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2020 оны 10 дугаар сарын 16 -ны өдөр

